



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/182

Номгон

Г

Г

Спиртийн өндөр агууламжтай согтууруулах  
ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийн  
хугацааг сунгах тухай

Монгол Улсын “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалт, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль”-ийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 14/08 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай” журмын 3.1, 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах 5, үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах 1 газрыг тус тус хавсралтаар баталсугай.

2.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан журам, шийдвэр, цагийн хуваарийг чанд мөрдөж, иргэдэд стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн худалдаалах, үйлчлэхийг иргэн, аж ахуйн нэгжийн эздэд үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Б.Оюутболд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.БАТЖАРГАЛ

1200884

Аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар  
сарын 31-ний өдрийн А/482 дугаар захирамжийн  
хавсралт



СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧЛЭХ  
"ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ"-ИЙН ХУГАЦААГ СУНГАХ  
ГАЗРУУДЫН НЭРС

№	Аж ахуйн нэгжийн өмчлөгчийн нэр	Цэг салбарын нэр	Цэг салбарын төрөл	Байршил	Шинээр олгох, сунгах эсэх	Өндөр болон сул агууламжтай эсэх
1	2	3	4	5	6	7
1	П.Батдэлгэр Вт73111311	"Наран"	Хүнсний дэлгүүр	БХР сум	сунгасан	Өндөр агууламжтай
2	З.Болортуяа Во90072404	"Болор"	хүнсний дэлгүүр	Өлзийт сум	сунгасан	Өндөр агууламжтай
3	З.Болортуяа Во90072404	"Болор"	Караоке, зоогийн газар	Өлзийт сум	сунгасан	Өндөр агууламжтай
4	Л.Нансалмаа Во63072601	"Хонгор нутаг"	Хүнсний дэлгүүр	Заг сум	сунгасан	Өндөр агууламжтай
5	Б.Баянаа Вм71112007	"Хийморь"	Хүнсний дэлгүүр	Жаргалант сум	сунгасан	Өндөр агууламжтай
6	А.Дашнамжил Ве70041201	"Баян-Арвижих"	Хүнсний дэлгүүр	Баянцагаан сум	сунгасан	Өндөр агууламжтай

оОо